

## АНХААР !!! ХАР ТАМХИ

Хар тамхины хууль бус худалдаа эрхлэгч этгээдүүд элдэв шалтаг шалтгаан тоочих, хөлс мөнгө амлах замаар гуравдагч этгээдэд дамжуулах эд зүйл өгөх, эсхүл юу болох нь тодорхойгүй



дайвар ачаа өгч тэдгээрт хар тамхи нууж хилээр нэвтрүүлэх тохиолдол их гарч байна. Монгол Улсын иргэд гадаад улсад зорчин явах

болон ирэхдээ бусдын дайвар ачаа, тээшийг биедээ болон биеэс тусдаа ачаа, илгээмжээр санамсаргүй, эсхүл хөлс төлбөртэйгөөр авч явахгүй байхыг анхааруулж байна.



Танд лавлах зүйл байна уу!



# 1800-1281

Гааль сонсож байна



Талархал



Гомдол



Асуулт



Санал

## ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор “Гаалийн лавлах-1281” нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлгөө өгөх, сурталчилгаа хийх болон гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



Хаяг:  
Сүхбаатар дүүрэг, "Их тойруу-81/1",  
Улаанбаатар-14193, Монгол Улс  
Утас: (976-11) - 350049  
Факс: (976-11) - 350048  
E-mail: info@customs.mn  
Интернет: <http://www.customs.gov.mn>



МОНГОЛ УЛСЫН  
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

## Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах төлбөрийн хэрэгслийг зорчигч улсын хилээр нэвтрүүлэхэд анхаарах зүйлс



УЛААНБААТАР ХОТ  
2019 ОН

**Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах төлбөрийн хэрэгслийг зорчигч улсын хилээр нэвтрүүлэхэд анхаарах зүйлс**

### Монгол Улсын хуулиас...

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт зааснаар 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг зорчигч Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх бол энэ тухай гаалийн мэдүүлэгт үнэн



зөв бичиж, гаалийн байгууллагад мэдүүлэх үүрэгтэй.

Хэрэв зорчигч та гаалийн байгууллагад үнэн зөв мэдүүлэг гаргахаас зайлсхийсэн, үнэн зөв мэдүүлэг гаргахаас татгалзсан, худал мэдүүлсэн бол Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлийн 22 дахь хэсэгт заасны дагуу зөрчилтэй төлбөрийн хэрэгслийн, эсхүл валютын үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүн, хуулийн этгээдийг зөрчилтэй төлбөрийн хэрэгслийн, эсхүл валютын үнийн дүнгийн 15 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл ногдуулах болохыг анхааруулж байна.

### Хөрш орнуудын гаалийн хуулиас...



БНХАУ-ын Гаалийн хуулийн дагуу тус улсын хилээр нэвтэрч байгаа гадаад улсын харьяат зорчигчид биедээ болон ачаа тээшиндээ авч яваа 5000 ам.доллараас их хэмжээтэй бэлэн мөнгийг гаальд мэдүүлэх үүрэгтэй. Тус улсын хилээр нэвтрэхэд гадаад валют, төлбөрийн карт, аяллын чек зэрэгт хязгаарлалт тавьдаггүй. Харин тус улсын мөнгөн дэвсгэрт юанийг 20000-аас дээш хэмжээгээр зорчигч бэлнээр нэвтрүүлэхийг хориглодог.



ОХУ-ын Холбооны Гаалийн хуулийн дагуу тус улсын хилээр орж байгаа зорчигчид 10000 ам.доллараас дээш үнэ бүхий бэлэн мөнгө, 1500 еврогоос дээш үнэ бүхий үнэт эдлэл, эртний эд зүйл болон бараатай бол, тус улсын хилээр гарч буй зорчигчид 3000 ам.доллар хүртэл бэлэн мөнгөтэй бол гаалийн мэдүүлэг бичих шаардлагагүй. Харин 10000 ам.доллар хүртэл бэлэн мөнгөтэй бол гаалийн мэдүүлэг бичнэ.

### Хариуцлага

Дээр дурьдсанаас их хэмжээний бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хэрэгсэл, үнэ бүхий зүйлийг БНХАУ, ОХУ-ын гаалийн байгууллагад мэдүүлэлгүй нэвтрүүлэхийг завдсан тохиолдолд торгох, баривчлах болон тухайн зөрчилд холбогдсон эд зүйлсийг хураах хүртэл хариуцлага ногдуулдаг.

Бараа, бүтээгдэхүүн импортоор оруулж гаалийн бүрдүүлэлт хийлгэхэд анхаарах зүйлс

Монгол Улсын иргэн, хуулийн этгээдүүд гадаад улсаас бараа, бүтээгдэхүүн импортоор оруулж ирэхдээ ачаа тээвэр, гаалийн бүрдүүлэлтийг хариуцан хийнэ гэсэн хувь хүмүүст хандаж төлбөр тооцоо хийж, итгэмжлэл олгосноор амар хялбар аргаар ашиг олох зорилго бүхий этгээдүүдийн хууль бус үйлдэлд холбогдох, эд хөрөнгө, цаг хугацаагаар хохирох, улмаар гаалийн зөрчилд холбогдон торгууль, шийтгэл хүлээх зэрэг өндөр эрсдэлд орж байна. Иймд гаалийн бүрдүүлэлт хийхдээ өөрийн нэр дээр, эсхүл хууль ёсны хамтран ажиллах гэрээний үндсэн дээр эрх бүхий гаалийн тээвэр зуучийн байгууллагаар дамжуулан хийлгэж байх нь таныг болзошгүй эрсдлээс сэргийлэх ач холбогдолтой.

